

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 2 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 2 дугаар сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1538 болж, 2015 мөн үеэс 871 хүнээр, өмнөх сарынхаас 234 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 45.38 хувь буюу 698 нь эмэгтэйчүүд юм. 2016 оны эхнээс 195 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 147 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 38.09 хувь буюу 56 нь эмэгтэйчүүд байв. Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 2 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 391 ажилгүй иргэний 24.04 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 23.79 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 15.86 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 6.14 хувь нь шилжин суурьшсан; 6.14 хувь нь орон тооны цомхтголд орсон; 5.37 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 3.32 хувь нь байгууллага татан буугдсан; 3.07 хувь нь цэргээс халагдсан; 2.05 хувь нь одоо

эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 2.05 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 0.26 хувь нь хорих газраас суллагдсан; 0.26 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.26 хувь нь тэтгэвэрт гарсан; 7.42 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 2 сард НДШ-ийн орлого 2.24 тэрбум ₮ болж төлөвлөгөө 94.7 хувь болж, төлөвлөгөөг 18 сум 0.7-26.6 хувиар давуулан биелүүлж. Аргалант, Архуст, Батсүмбэр, Баянжаргалан, Баянхангай, Заамар, Өндөрширээт, Цээл, Зуунмод сумд 2.55-18.2 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 171.1 сая ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 6.43 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.9 хувийг өндөр настны, 10.2 хувийг

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 265340 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 33.36 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 18.65%; тэтгэмжийн даатгалын сангийн 93.46%; эрүүл мэндийн даатгалын сангийн 282.64%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 48.81%; ажилгүйдлийн даатгалын сангийн 101.22%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 2 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 35375 хүнд олгож, 1.9 тэрбум ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 21.15 хувь 9492 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 18.68 хувь 451.7 сая ₮-өөр буурлаа.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 105980 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 58.4 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 23.7 хувийг халамжийн тэтгэвэр; 7.9 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.5 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.0 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 0.5 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.7 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



1.3 Эрүүл мэнд

2016 оны эхний 2 сард 2563 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.88 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 2 сард 198 хүүхэд мэндэлсэн нь 2015 оны мөн үеэс 17 хүүхдээр өслөө.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



Он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 8 хүүхдээр өслөө.

Зураг 1.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар




2016 оны эхний 2 сард халдварт өвчнөөр 157 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 82.5 хувь буюу 71 хүнээр өслөө. 2015 оны мөн үеэс заг хүйтэн 2.2 дахин, салхин цэцэг 2,1 дахин, вируст хепатит 1,0 дахин, тэмбүү 23.3 хувь, сүрьеэ 6.7 хувь, бусад өвчлөл 28.6 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт

өвчлөл аймгийн дундаж 17 байгаа бол: Зуунмод 62, Угтаал 23, Мөнгөнморьт 20, Баян-Өнжүүлд 19 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



I.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Цаг агаарын тойм

2016 ОНЫ ГУРАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сарын агаарын дундаж температур нь 6-11 градус хүйтэн байх ба олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй.

Дулаарах үе: Гуравдугаар арав хоногийн дунд үеэр харьцангуй дулаарч ихэнх нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна.

Хүйтрэх үе: Нэг болон хоёрдугаар арав хоногийн эх болон сүүлчээр хүйтэрч томоохон голын хөндийгөөр шөнөдөө 27-32 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 20-25 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байна.

Бусад хугацаанд: Ихэнх нутгаар шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан байна. Энэ сард дунджийн орчим хур тунадас

орох төлөвтэй. Дундаж нь 2.0-5.0 мм орчим.

Нэгдүгээр арав хоногийн эхээр ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар цас, гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, сүүлчээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар 16-18 м/с, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар 12-14 м/с зарим үед 18-20 м/с хүртэл ширүүсч цасан ба шороон шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

3 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим, хур тунадас ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим орохоор байна. 2 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгаар цастай байгаагаас зарим сумдын нутгаар 0-4 см буюу тарлан цастай, ихэнх сумдын нутгаар 5-11 см зузаан буюу нягт нь 0,03-0,14 гр/см³, Угтаал, Жаргалант, Нөхөрлөл сумдын нутгаар 12-23 см зузаан буюу нягт нь 0,15-0,24 гр/см³ байна. Цаашид 3 дугаар сард үе үе цасан болон шороон шуурга шуурч мал төллүүлэх, малын бэлчээрлэлтэнд таагүй нөлөөлж болзошгүйг онцгой анхаарна уу.

2016 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын дундаж температур зүүн хэсгээр 3 градус хүйтнээс 1 градус дулаан, бусад нутгаар 2-7 градус дулаан буюу олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард зүүн хэсгээр олон жилийн дунджаас

ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 2 сард аймгийн хэмжээнд 128 гэмт хэрэг бүртгэгдэж 97 хүн холбогдож иргэдийн өмчид 375.2 сая ₮-ийн хохирол учирлаа.


Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



Гарсан гэмт хэргийн 45.3 хувь нь хулгай, 28.8 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг хэрэг, 10.2 хувь нь замын осол, 3.9 хувь нь танхай дээрэм, 0.8 хувь нь хүн амины хэрэг, 0.0 хувь нь өмчийн, 14.1 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Баянжаргалан, Сэргэлэн, Баянхангай, Аргалант, Баянчандмань

сумдад 18 дээш насны 10000 хүнд 66-33 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (21)-аас харьцангуй их гарлаа.

Зураг 1.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 25 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 5 эмэгтэй, 128 эрэгтэй нийт 133 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оны мөн үеэс 47 хүнээр буурлаа. 24 хүн баривчлагдлаа.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 оны эхний 2 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 293 гүйцэтгэх хуудсанд нийт 1.76 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 3 гүйцэтгэх хуудсанд ногдох 146.5 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 290 гүйцэтгэх хуудасны 1.61 тэрбум ₮-өөс 64 хуудасны 141.6 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 22.07 хувь, үнийн дүнгээр 8.77 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 0.33 нэгжээр өсч, үнийн дүнгийн биелэлт 8.18 нэгжээр буурлаа.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 2 сард кассын орлого 65.8 тэрбум ₮, кассын зарлага 65.5 тэрбум ₮ болж, гүйлгээнд 128.5 тэрбум ₮ байна. ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 49348, зээлийн багцын дүн 159.5 тэрбум ₮, зээл авсан зээлдэгийн тоо 14464, олгосон зээлийн дүн 22.9 тэрбум ₮ боллоо.

Иргэдийн хувийн хадгаламжинд 2 сарын 29-ний байдлаар хугацаатай хадгаламж 8.6 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 37.1 тэрбум ₮ байна.

Харилцах дансны үлдэгдэл 2 сарын 29-ны байдлаар 175261 иргэний 4.9 тэрбум ₮ боллоо. ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 0.76-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



II. Төсвийн орлого 2016 оны эхний 2 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 1.2 тэрбум ₮, зарлага 9.6 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 81.37 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; Татварын орлого, хувь хүний орлогын албан татвар, өмчийн татвар, үл хөдлөх хөрөнгө, бууны албан татвар, бусад албан татвар, төлбөр, хураамжийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй. Аймагын төсвийн орлого 2015 оны мөн үеэс 5.1 хувь буюу 61.2 сая ₮-өөр өслөө. Аймагын

төсвийн орлогын 91.5 хувийг татварын, 8.0 хувийг татварын бус, 0.4 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 10.5 нэгжээр өч, татварын бус орлого 10.7 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 0.2 нэгжээр өслөө.

Аймагын нийт 3 шатны орлого 1388.4 сая ₮ болж аймагийнх 1155.3 сая ₮ буюу 83.21 хувь, сумынх 113.3 сая ₮ буюу 8.16 хувь, улсынх 119.8 сая ₮ буюу 8.63 хувийг тус бүр бүрдүүлжээ. 2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 15.5 хувь буюу 174.9 сая ₮-өөр буурч 927.1 сая ₮ болж, авлага 24.3 хувь буюу 30.8 сая ₮-өөр буурч 157.6 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 1.1 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 80.83 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 113.3 сая ₮ болж, төлөвлөгөө 69.70 хувь биелж, Угтаал, Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Батсүмбэр, Дэлгэрхаан, Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Архуст, Баянхангай, Зуунмод, Сэргэлэн, Баянцагаан, Мөнгөнморьт, Баянцогт, Баян, Өндөрширээт, Заамар, Борнуур сумд 84.75-3.97 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 1.1 тэрбум ₮ болж 82.73 хувь биелж Эрдэнэсант, Эрдэнэ, Баянцагаан, Өндөрширээт, Баянчандмань, Жаргалант, Баянцогт, Баян, Угтаал, Батсүмбэр, Борнуур, Сүмбэр, Зуунмод, Алтанбулаг, Бүрэн, Баяндэлгэр, Цээл, Баянжаргалан, Мөнгөнморьт сумд төлөвлөгөө 60.1-1.48 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2016 оны 2 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 62.56%, өмнөх оны мөн үеэс 6.40%, өмнөх сараас 0.10 хувиар тус тус өсөв.

Бараа, үйлчилгээний бүлэг	2016 оны 2 сард	
	пунктээр	хувийг
Бүгд	0.10	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.34	340.95%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.00	0.00%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.00	-1.39%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.00	4.86%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	-0.27	-263.24%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	19.02%

ХҮИ-ийн 2016 оны 2 дугаар сарын 0.10 хувийн өсөлтийн 0.34 нэгж нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн; 0.02 нэгж нь бусад бараа үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаасан боловч тээврийн бүлгийн 0.27 нэгж бууралт нийт дүнд сайнаар нөлөөлөв.

ХҮИ өмнөх оны мөн үеэс 6.40% өссөний дотор боловсролын үйлчилгээний бүлэг 32.5%; хувцас бөс бараа гутлын бүлэг 10.96%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 8.18%; тээврийн бүлэг 7.71%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 6.46%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 4.87%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 2.50%; амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 0.19%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 4.54%-аар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 3.1%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.03%-аар тус тус буурч зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны

үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байв.

Зураг II.4

Хэрэглээний үнийн индекс оны эхнээс, хувиар



II. Том малын зүй бус хорогдол


2016 оны 3 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.47 хувь буюу 20968 том мал зүй бусаар хорогдсон нь 2015 оны мөн үеэс 14.1 дахин буюу 19580 толгойгоор; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 21.1 хувь буюу 3662 толгойгоор тус бүр өслөө. Хамгийн их хорогдолтой 5 сум Угтаал, Баянхангай, Баянцогт, Бүрэн, Сүмбэр сумд оны эхний малынхаа 1.98-0.97 хувь буюу 4165-367 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 49.2 хувь (бүгд 10323) эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо, төрлөөр толгой

	2012	2013	2014	2015	2016
Бүгд	2878	6938	2397	1388	20968
Тэмээ	0	1	2	1	8
Адуу	331	406	266	202	1252
Үхэр	252	544	200	172	2341
Хонь	1067	2771	959	519	7687
Ямаа	1228	3216	970	494	9680

Оны эхний тэмээний 0.26; адууны 0.35; үхрийн 0.74; хонины 0.34; ямааны 0.64 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 4.2 хувь нь өвчнөөр, 22.6 хувь нь хээлтэгч мал эзлэв.

Том малын зүй бус хорогдол, сумаар, толгойгоор



II.5 Аж үйлдвэр

2016 оны эхний 2 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 728.15 сая ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 47.7 хувь буюу 664.5 сая ₮-өөр буурлаа.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая ₮-д
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2015 II	2016 II	2015 II	2016 II	Дүнд эзлэх % Percentage share to total		2016/2015%
					2015-II	2016-II	
Нийт дүн	488.27	254.76	1,392.66	728.15	100.0	100.0	52.3%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying				7.77	0.00%	1.07	
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	206.16	90.52	918.34	367.96	65.94	50.53	40.1%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	282.11	164.24	474.32	352.42	34.1	48.40	74.3%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл, цахилгаан дулааны үйлдвэрлэл өмнөх оноос 70.5-25.7 хувь буюу 418.15-5.1 сая ₮-өөр буурсан нь нөлөөлөв.


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Батсүмбэр, Эрдэнэ, Угтаалцайд, Баянцагаан сумд 73.19-2.15 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 79.07) хувийг эзлэв

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, хувиар






II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 2 сард 30.8 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 14.2 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.6 хувь буюу 2.5 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 14.5 сая ₮ болсон ба нийт орлогын 78.07 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 26.11 хувийг албан бичгийн, 11.23 хувийг зорчигчдын, 62.66 хувийг бусад орлого бүрдүүллээ.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 2 сарын мэдээгээр нийт 37 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 66; үүнээс тохирлын гэрчилгээ 60, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 6; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 168; үүнээс цулын хэмжүүр 97, жин 76, туухай 21; усны

тоолуур 3; нэг фазын тоолуур 68 тус бүр баталгаажуулсан байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 2 сард нийт 712 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 49; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 318; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 2; бэлэглэлийн гэрээ 35; худалдах, худалдан авах гэрээ 29; өв залгамжлал 2; барьцааны гэрээ 212; бусад бүртгэл 65 тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 2 сард нийт 21 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 10; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 5; гишүүдэдээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 3; шашин 1; төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар /ТБАГУТҮГ/ 2 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 2 сарын мэдээгээр 62 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 5; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 13; дүрэм шинчилсэн 1; дахин гэрчилгээ 2; удирдлага өөрчлөгдсөн 12; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 7; дүрмийн сан нэмэгдсэн 11; татан буугдсан 7; нэр өөрчлөгдсөн 4 тус бүр бүртгүүллээ.